



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН А.АРИУНЗАЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.02.04 № 1/682

танай 2025.01.22 -ны № 03 -т

Хариу хүргүүлэх тухай


Танаас ирүүлсэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон шийдвэр нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт тус тус заасан хугацаа тогтоосон заалтуудтай нийцэж байгаа эсэх талаарх асуулттай танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтад тус тус зааснаар хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг тайлбарлах эрхийг гагцхүү Улсын дээд шүүх хэрэгжүүлж байгаа бөгөөд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй бодлогын асуудлаар тайлбар, мэдээлэл хүргүүлэх нь хууль дээдлэх зарчимд нийцэхгүй юм.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бол тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагч /цаашид "ажилтан" гэх/-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар бөгөөд үүнийг мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалтад зааснаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо тогтоох, шинэчлэн тогтоох эрхтэй байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо энэ хуулийн 4.2-т заасан хүчин зүйлийг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох бөгөөд энэ хуулийн 6.1, 6.2-т заасан саналын дагуу шинэчлэн тогтоож болно" гэж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтооход хамаарах ерөнхий хугацаа, давтамж болон шинэчлэн тогтооход хамаарах нөхцлийг тодорхой хугацаа тогтоолгүйгээр заажээ.

Харин Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосон тохиолдолд түүнийг дагаж мөрдүүлэх хугацаа нь дараагийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр байна. Хэрэв тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш шинэчлэн тогтоосон бол дараагийн төсвийн жилээс эхлэн дагаж мөрдүүлнэ." гэж заасан хугацаа нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг энэ хуулийн 6.1, 6.2-т заасан саналын дагуу шинэчлэн тогтоож болно" гэж заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтооход хамаарах хугацаа байхаар ойлгогдож байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151600563



پیشتر سے پہلے میں نے کہا تھا کہ میں نے
میں نے یہ سب سیکھا ہے۔

[illegible][illegible]

۲۵ .. سید حسن علی

Handwritten text in Arabic script, likely a signature or name, written in blue ink. The text is partially obscured by red rectangular stamps or markings.

15160301